



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/02

Хажуу шинэ-Ус

2024 оны цэргийн бүртгэл явуулах
ажлын хэсэг байгуулах тухай

“Цэргийн албаны тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт 34 дүгээр зүйл, батлан хамгаалахын сайдын 2017 оны А/322 тоот тушаалаар батлагдсан “Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам”, Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/708 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны Цэргийн бүртгэл явуулах сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Өлзийтогтох(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Б.Наранбаатар (Хэсгийн цагдаа)

А.Бямбасүрэн (3 дугаар багийн эмч)

П.Цэцэгмаа (Бага эмч)

М.Амарзаяа (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Даваасүрэн (3 дугаар багийн Засаг дарга)

Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)


2.Сумын хугацаат цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл үүрэгтэй иргэдийн бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 08-ний өдрөөс 01 дүгээр сарын 25-ний дотор зохион явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

3.Цэргийн тоо бүртгэл явуулах байрыг Засаг даргын Тамгын газрын иргэний танхимаар тогтоосугай.

4.Монгол Улс Дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль,Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад заагдсан “Улсын дайчилгааны төлөвлөгөө” болон Сумын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний дагуу сумын хуулийн этгээдүүдийн улсын дайчилгааны даалгавар орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтэй иргэд, авто техник, өөрөө явагч хэрэгсэл, ангийн буу зэргийг нэг бүрчлэн бүртгэн тоолохыг ажлын хэсэгт даалгасугай.

5.Тоо бүртгэлийн үеэр “Батлан хамгаалах”-ийн хууль тогтоомж, цэргийн жинхэнэ болон гэрээт цэргийн албыг сурталчлан сургалт зохион байгуулж тайланг хугацаанд нь явуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Өлзийтогтох)-д даалгасугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482301002